

# SikaTop® Seal 107

## Цементэн суурьтай уснаас хамгаалах зуурмаг

### Бүтээгдэхүүний тодорхойлолт

SikaTop® Seal 107 нь полимер агуулсан цементэн суурьтай ус, чийгнээс хамгаалах шингэн түрхлэг юм.

SikaTop® Seal 107 нь EN 1504-2 стандартын нөхцлийг хангасан хамгаалалтын түрхлэг болно.

### Хэрэглээ:

SikaTop® Seal 107 нь доорхи тохиолдлуудад хэрэглэгдэнэ:

- Бетон, цементэн, тоосгон ба блок гадаргуутай барилгын гадна болон дотор талыг ус, чийгнээс хамгаалах зорилгоор
- Бетонон эдлэлийг хөлдөх гэсэх үйл явцын нөлөөллөөс хамгаалах зорилгоор
- Шинээр барьж байгаа болон засварлаж байгаа барилгын доод суурьны ханыг ус, чийгнээс хамгаалах зорилгоор
- Бетоны гадаргууд үүссэн нүх сүвийг битүүлэхэд
- Барилгын суурь болон зоорьны хэсгийг ус чийгнээс хамгаалахад
- Бетонон эдлэл дэх хялгасан ан цавыг битүүлэх зорилгоор
- Бетоны гадаргууг засах болон тэгшлэх шавардлага

SikaTop® Seal 107 нь бетонд дараах төрлийн хамгаалалт үүсгэнэ:

- Усны нэвчилтээс хамгаалах (EN 1504-9 стандартын аргачлал 1.3, зарчим 1-ийн дагуу)
- Чийгний хязгаарлалт (EN 1504-9 стандартын аргачлал 2.2, зарчим 2-ийн дагуу)
- Эсэргүүцлийг нэмэгдүүлэх (EN 1504-9 стандартын аргачлал 8.2, зарчим 8-ийн дагуу)

### Бүтээгдэхүүний шинж чанар ба давуу талууд

- Багс болон нивигээр жигд түрхэхэд хялбар
- Ус нэмэх шаардлага байхгүй
- Шууд хэрэглэхэд зориулсан бэлэн зуурмаг
- Шүрших болон гар засварт зориулсан
- Зуурмаг нь хурдан бөгөөд хялбар холигддог
- Барьцалдах чадвар маш сайн
- Бетоныг нүүрсхүчлээр баяжхаас хамгаалдаг
- Бетонд ус, чийг нэвтрэхээс хамгаалдаг
- Ган болон төмөр эдлэлийг зэврүүлдэггүй
- Дээрээс нь давхар түрхлэг түрхэх боломжтой
- Ундны усны зориулалтанд хэрэглэхэд зөвшөөрөгдсөн



## Бүтээгдэхүүний мэдээллийн хуудас

**Зөвшөөрөл/Стандарт** SikaTop® Seal 107 нь ундны устай шууд хүрэлцэхэд сөрөг нөлөөгүй гэдэг нь доорх стандартуудаар нотлогдсон:

British Board of Agreement Certificate No. 95/3174

## Хэлбэр/Төлөв

<b>Гадаад байдал</b>	А хэсэг:	Цагаан өнгөтэй шингэн
	Б хэсэг:	Саарал болон цагаан өнгөтэй нунтаг
	Зуурсан бүтээгдэхүүн:	Цементэн саарал болон цагаан өнгийн зуурмаг

**Сав баглаа боодол** 25кг сет бүтээгдэхүүн (20кг нунтаг + 5кг шингэн)  
12,5кг сет бүтээгдэхүүн (2х5кг нунтаг + 2х1,25л шингэн)

## Хадгалалт

**Хадгалалтын нөхцөл** Үйлдвэрлэсэн өдрөөс 6 сарын хугацаанд хуурай сэрүүн нөхцөлд хадгална. Шингэн бүтээгдэхүүнийг хөлдөөхөөс сэргийл

## Техникийн үзүүлэлт

**Химийн суурь** А хэсэг: нэмэлт бүхий шингэн полимер  
Б хэсэг: Портланд цемент, шилмэл хайрга болон нэмэлтүүд

**Нягт** Шингэн зуурмагын нягт: ~2,00 кг/литр

**Үе давхрагын зузаан** Хамгийн багадаа 0,75 мм  
Хамгийн ихдээ 1,5 мм

## Механик / Физик хүчин зүйлүүд

**Шахалтын бат бэх** (EN 196-1д нийцсэн)

3 хоногт	~20 N/mm <sup>2</sup>
28 хоногт	~35 N/mm <sup>2</sup>

**Гулзайлтын бат бэх** (EN 196-1д нийцсэн)

3 хоногт	~6 N/mm <sup>2</sup>
28 хоногт	~10 N/mm <sup>2</sup>

**Сунгалтын бат бэх** (DIN 53455д нийцсэн)

усанд бэхжүүлэхэд: ~3,2 N/mm<sup>2</sup> (14 хоног ил тавьсаны дараа)  
агаарт бэхжүүлэхэд: ~4,5 N/mm<sup>2</sup> (14 хоног ил тавьсаны дараа)

**Барьцалтын бат бэх** 2,0-3,0 N/mm<sup>2</sup> (гадаргуун гэмтэл)

**E-Модуль** ~8,4 kN/mm<sup>2</sup>

## Системийн мэдээлэл

<b>Хэрэглээ</b>	Гадаргууны арзгараас шалтгаалан шаварлагааны зузаан тодорхойлогдоно.  Ойролцоогоор ~2,0 kg/m <sup>2</sup> /mm (хаягдал, гадаргууны төлөв, нүхжилт г.м-ийг тооцоогүй болно )  25кг савлагаатай 1 сет бүтээгдэхүүн нь ~12,5 л шавар зуурмаг болно.
<b>Гадаргууны чанар</b>	Бетоны гадаргуу бат бэх, тос тосоол барилгын хог бохирдолгүй цэвэр, сул бутарсан хэсэггүй байх ёстой.

<b>Гадаргууг бэлдэх</b>	<p><u>Ерөнхий:</u> Өндөр даралтат усан компрессор, тогшилтод алх, арзайлгагч зүлгүүр г.м багажаар гадаргууг цэвэрлэж бэлдсэний дараа гадаргууг сайтар чийглэнэ.</p> <p><u>Гадаргуу дахь нүх сүвийг битүүлэхэд :</u> Бетоны гадаргууд үүссэн нүх сүвэн дэх бохирдлыг өндөр даралтат усан компрессороор сайтар цэвэрлэнэ.</p> <p><u>Гадаргууг тэгшлэх зорилгоор:</u> Хийн зүлгүүр буюу түүнтэй ижил төрлийн багажаар гадаргуун дээрх гэмтэлтэй хэсгүүд, нүх сүв, арзайлттай хэсгийг бүрэн цэвэрлэж өгнө.</p>
-------------------------	--

## Хэрэглэх нөхцлүүд

<b>Гадаргууны температур</b>	+8°C min. / +35°C max.
<b>Орчны температур</b>	+8°C min. / +35°C max.

## Хэрэглэх заавар

<b>Холих</b>	A : B = 1 : 4
<b>Холих хугацаа</b>	~ 3 minutes
<b>Холих багаж</b>	SikaTop® Seal 107-ийг зориулалтын холигч багаж ашиглаж хольно.

<b>Хэрэглэж аргачлал /</b>	А хэсгийг хэрэглэхээс өмнө сайтар сэгсэр. Ойролцоогоор А хэсгийн талыг холих хувинд хийгээд Б хэсгийг бага багаар хийж холигчоор хольж өгнө. Үлдсэн А хэсгийг хувиндаа хийгээд зуурмагаа жигд зуурмаг болтол хольно. Хэрэглэх гадаргуунд түрхэхээс өмнө гадаргуугаа чийглэсэн байна.
----------------------------	--

### Шингэн зуурмаг:

Шингэн зуурмагаа шүрших буюу ширүүн багсаар нэгэн жигд дээрээс доош чиглэлтэй түрх. Эхний үе хатсаны дараа 2дахь үеэ хөндлөн чигт түрхэнэ

### Шавардлага хийх тохиолдолд:

А хэсгээс 10%-ийг үлдээж өтгөн зуурмаг хэлбэрээр хэрэглэнэ. Эхний үеэ нивигээр түрхээд, хатсаны дараа 2дахь үеийг түрхэнэ. Нүх сүвийг битүүлэхдээ нивигээр сайтар дарж түрхэнэ.

<b>Багажаа цэвэрлэх</b>	Бүтээгдэхүүнийг хэрэглэж дууссаны дараа багажуудаа усаар сайтар цэвэрлэнэ. Багаж дээр хатаж тогтсон зуурмагийг механик аргаар цэвэрлэнэ.
-------------------------	--

**Хүлээх хугацаа /  
2дахь үе**

Үе хооронд хүлээгдэх хугацаа:

+10 °C	~12 цаг
+20 °C	~6 цаг
+30 °C	~3 цаг

Үе хоорондын хугацаа 24 цагаас хэтэрвэл, гадаргууг дахиад бага зэрэг арзайлгах хэрэгтэй.

SikaTop® Seal 107-ийн дээрээс шингэлэгч агуулсан суурь түрхлэг түрхэж болно. SikaTop® Seal 107-г дор хаяж 7 хоног бүрэн бэхжүүлсэний дараа дээрээс нь түрхлэг түрхэж болно.

**Анхаарах зүйл**

SikaTop® Seal 107 нь гоёлын давхрага биш бөгөөд бороо орсны дараа гадаргуу нь цайрч харагдаж болзошгүй. Гэхдээ энэ нь бүтээгдэхүүний үйлчлэлд ямар нэгэн нөлөө үзүүлэхгүй болно. SikaTop® Seal 107-г түрхсэн гадаргуу ил задгай үлдэх шаардлагатай тохиолдолд цагаан өнгийн SikaTop® Seal 107-г хэрэглэх нь илүү үзэмжтэй болно.

Гүйцэтгэлийг хийхдээ нарны шууд тусгалтай болон ширүүн салхитай үед хийхгүй байхыг зөвлөж байна. Зуурмагт зориулалтын шингэнээс өөр шингэн буюу ус хэзээ ч хийж болохгүй. Энэхүү Техникийн үзүүлэлтэнд заасан хэмжээнээс илүү зузаан түрхэж болохгүй.

Ус, чийгнээс хамгаалал зориулалтаас хийх шавардлага заавал 2 үе түрхэх шаардлагатай бөгөөд, шавардлагын нийт зузаан 1,5-2,0 мм байх хэрэгтэй. Усны нэвчилт ихтэй газар 3 дахь үеийг нэмж түрхэх шаардлагатай.

Шинээр түрхсэн ус тусгаарлагч шавардлагыг бороо шороо болон хөлдөлтөөс хамгаалах хэрэгтэй.

SikaTop® Seal 107 нь үрэлт хөдөлгөөнд тэсвэртэй шавардлага биш юм. Иймээс үрэлт, хөдөлгөөн ихтэй газруудад SikaTop® Seal 107-хамгаалж, Sika®Latex болон Sika®-1, SikaTop®-77, SikaCem®-810 зэрэг бүтээгдэхүүнийг нимгэн түрхэж өгнө

Ус, чийгнээс хамгаалах түрхлэг хийсэн газруудад нүхлэх, цоолох г.м нэмэлт засварын ажлууд гарч болзошгүй тохиолдолд SikaDur®-31 SikaFlex®-Construction зэрэг бүтээгдэхүүнийг хавсарч хэрэглэж эргэн тойронд үүсэх зай завсарт чигжих хэрэгтэй

Ундны усны зориулалттай бүтээцэд ус чийгнээс хамгаалах бүтээгдэхүүн хэрэглэх гэж байгаа тохиолдолд тухайн улсын ундны усны Эрүүл ахуйн стандартад нийцсэн Sika® брендийн бүтээгдэхүүнүүдийг хэрэглэх шаардлагатай .

**Бэхжилт,  
Арчилгааны  
мэдээлэл**

SikaTop® Seal 107-г түрхсэний дараа болзошгүй хагарлаас сэргийлж дор хаяж 3-5 хоног бүрэн бэхжилт авахуулах хэрэгтэй. Үүний тулд политлен гялгар хучлага буюу түүнтэй ижил төрлийн материал хучих боломжтой.

**Дүгнэлт:**

Бүтээгдэхүүний мэдээллийн энэхүү маягтад лабораторийн туршилтын үндсэн дээр батлагдсан техникийн үзүүлэлтүүд тусгагдсан ба бодит үзүүлэлтүүд нь тухайн нөхцөл байдалд өөр өөр байж болно гэдгийг анхаарна уу.

**Дотоодын хязгаарлалт**

Тухайн улс орны дотоодын хууль тогтоомжоос хамааран уг бүтээгдэхүүний гүйцэтгэл зөрүүтэй хийгдэх боломжтой. Иймээс манай Техникийн хэлтэстэй холбогдож зөвлөгөө авах боломжтой.

## Эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны талаар мэдээлэл

**Аюулгүй ажиллагааны анхааруулга:** Аюулгүй ажиллагааны талаарх дэлгэрэнгүй мэдээллийг физик, экологи, хортой байдал, бусад аюулгүй ажиллагаатай холбоотой мэдээллийг цогцоор агуулсан Материалын Аюулгүй ажиллагааны мэдээллийн хуудаснаас авах бүрэн боломжтой. Мөн хадгалалт, химийн бодисын устгал зэрэг мэдээллийг тухайн хуудаснаас авч болно.

**Хууль эрх зүйн мэдээлэл**

Энэхүү маягтан дээр ерөнхий мэдээлэл нь Sika бүтээгдэхүүнийг хэрэглэх, хадгалах, ердийн нөхцөлд боловсруулалт хийх зааврыг агуулсан ба эдгээр мэдээлэл нь Sika бүтээгдэхүүний талаар олж авсан мэдээлэл болон ойлголт дээрээ үндэслэсэн болно. Тиймээс зарим төрлийн бүтээгдэхүүн нь хэрэглэх талбай, талбайн тухайн үеийн нөхцөлд зэрэгтэй уялдан харилцан адилгүй нөлөөлөл үзүүлдэг тул энэхүү мэдээллийн хуудас нь тухайн бүтээгдэхүүний баталгааны хуудас болж чадахгүй гэдгийг онцлон тэмдэглэж байна. Sika бүтээгдэхүүнийг өгөгдсөн зааврын дагуу хэрэглэсний улмаас үүсэж болзошгүй аливаа нэгэн асуудалтай холбоотой хууль эрх зүйн хариуцлага хүлээх боломжгүй юм. Бүтээгдэхүүний захиалгыгөнөөгийн хүлээн зөвшөөрөгдсөн нөхцөл болон хүргэлтийн шаардлагын дагуу хүлээн авах ба бүтээгдхүүнтэй холбоотой өөрчлөлтийг хэрэглэгч нь үйлдвэрлэгчид албан ёсоор хүсэлт гаргасны үндсэн дээр авч болно.